



БАГШИЙН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл


- 1.1 Багшийн хөгжлийн төв /цаашид төв гэх/ нь Их сургуулийн багшийн мэргэжил дээшлүүлэх үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангаж зохион байгуулах, багшийн өөрийн хөгжлийн үйл явцыг дэмжих чиг үүрэг бүхий үйлчилгээний нэгж байна.
- 1.2 Төвийн зорилго нь багшийн тогтвортой хөгжлийг хангах, мэдлэг боловсролыг олон улсын түвшинд хүргэх, тасралтгүйгээр бие даан хөгжих нөхцөлийг бүрдүүлэх, үр бүтээлтэй ажиллах хөшүүргийг бий болгох, гүйцэтгэлийн соёл өндөртэй багшлах залгамж халааг дэмжин чадавхижуулахад оршино.
- 1.3 Төв нь үйл ажиллагаандаа Монгол Улсын холбогдох хууль тогтоомж болон тэдгээрт нийцүүлэн гаргасан эрх зүйн бусад баримт бичгүүд, “Боловсролын чанарын шинэчлэлийн бодлого” /2012-2016/, “Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого” /2014-2024/, “ШУТИС-ийн хөгжлийн стратегийн замын зураглал” /2012-2021/, ШУТИС-ийн дүрэм, журам ба энэхүү дүрмийг мөрдлөг болгоно.
- 1.4 Төв нь үйл ажиллагаандаа тогтоосон журмын дагуу үйлдсэн тэмдэг хэрэглэнэ.
- 1.5 Төв нь үйл ажиллагаандаа шинжлэх ухаанч ажил хэрэгч байдлыг хангаж, хууль дээдлэх олон ургалч үзлийг хүндэтгэх, ил тод ажиллах зарчмыг баримтална.

Хоёр. Төвийн бүтэц зохион байгуулалт

- 2.1 Төв нь Боловсрол эрхэлсэн проректорт харьяалагдан үйл ажиллагаа явуулна.
- 2.2 Төвийн өдөр тутмын үйл ажиллагааг төвийн захирал удирдах бөгөөд ажлаа Боловсрол ба Эрдэм шинжилгээ, инноваци эрхэлсэн проректоруудад тус тус тайлагнана.
- 2.3 Төвийн орон тоо, албан тушаал, цалинг үйл ажиллагааны цар хүрээнээс хамааруулан Ректорын тушаалаар батална.
- 2.4 Бүрэлдэхүүн сургууль, институт дээр багшийн хөгжлийн багууд төвийн үйл ажиллагааг зохион байгуулан ажиллах бөгөөд баг бүрд Ректорын тушаалаар батлагдсан орон тооны бус 3-5 багш ажиллана.
- 2.5 Төв нь мэргэжил дээшлүүлэх байнгын сургалтуудыг холбогдох проректорууд, алба, нэгжүүд, бүрэлдэхүүн сургууль, институт, төвүүдтэй хамтран зохион байгуулна.
- 2.6 Төвийн үйл ажиллагааны тайланг Ректорын зөвлөлийн хурлаар хичээлийн жилийн эцэст хэлэлцэж, төвийн үйл ажиллагааны чиглэлд тодотгол оруулна.
- 2.7 Багшийн хөгжлийн төвийн үйл ажиллагааг Вэб хуудсаар дамжуулан сурталчилна.
- 2.8 Төвийн захирал нь дараах эрх үүрэгтэй байна.
 - 2.8.1 Төвийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллана.
 - 2.8.2 ШУТИС-ийн ажлын байр /албан тушаал/-ны тодорхойлолтод тусгагдсан чиг үүргийг хэрэгжүүлнэ.
 - 2.8.3 Төвийн багш нарыг сонгон шалгаруулж ажилд авах ба ажлаас чөлөөлөх санал гаргах эрхтэй.

Гурав. Төвийн үйл ажиллагааны чиглэл

- 3.1 Төвийн үйл ажиллагааны төлөвлөгөөг Боловсрол ба Эрдэм шинжилгээ инноваци эрхэлсэн проректорууд батална.



- 3.2 Төв нь дараах үйл ажиллагааг явуулна. Үүнд:
- 3.2.1 Олон улсын дээд боловсролын хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн багш нарыг чадавхижуулах зорилгоор, сургалт ба чанарын үнэлгээний чиглэлд; судалгаа ба инновацийн чиглэлд; олон нийтэд үзүүлэх үйлчилгээний чиглэлд; их сургуулийн гүйцэтгэлийн соёлын чиглэлд; хувь хүний төлөвшлийн чиглэлд тус тус сургалтуудыг тогтмол зохион байгуулах
 - 3.2.2 Багш нарыг дотоод, гадаадын тэтгэлэг, төсөл хөтөлбөрт хамруулах, гадаадын нэр хүнд бүхий их, дээд сургууль, хүрээлэнгүүд, судалгааны лабораториудад судлаачидтай хамтран ажиллах, туршлага солилцох, мэргэжил дээшлүүлэхэд дэмжлэг туслалцаа үзүүлэх, зуучлах, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах
 - 3.2.3 Их сургуулийн сургалт-судалгааны ажлын уялдаа холбоог сайжруулах, хамтарсан профессорын багуудын үйл ажиллагааг тогтворжуулах, судалгааны их сургуулийн судлаач багшийг үе шаттайгаар бэлтгэхэд хамтран ажиллах
 - 3.2.4 Их, дээд сургуулийн багш нар харилцан туршлага солилцож, хамтдаа хөгжихөд чиглэсэн нийтийн, насан туршийн, нээлттэй сургалтын орчинг бүрдүүлэх, сургах ба суралцахуйн үйл явцыг бүтээлчээр удирдан зохион байгуулах багшийг төлөвшүүлэх
 - 3.2.5 Инженерийн боловсролын шинэчлэлийн CDIO санаачлага дахь багшийн стандартуудыг нутагшуулах, дотоодын болон гадаадын мэргэжлийн байгууллага, холбоодтой хамтран багшийн хөгжлийг дэмжих хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх, дагалдан багш нарыг үйлдвэрлэлийн дадлага хийх боломжоор хангах
 - 3.2.6 Багш нарын мэргэжил дээшлүүлэх хэрэгцээний судалгааг гаргаж, мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, багшийн өөрийн хөгжлийн загварыг боловсруулах
 - 3.2.7 Их сургуулийн багшийн гарын авлага, мэргэжил дээшлүүлэх сургалтанд хэрэглэгдэх ном, гарын авлага, зөвлөмжийг боловсруулж бэлтгэх, багш нарын хүртээл болгох
 - 3.2.8 Гадаадын их, дээд сургуулиудын ижил төстэй төвүүд, олон улсын хүний хөгжлийн байгууллагуудтай хамтран ажиллах, хамтын ажиллагааг зохих түвшинд гаргах

Дөрөв. Төвийн санхүүжилт

- 4.1 Төвийн үйл ажиллагааг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ. Үүнд:
- 4.1.1 Багшийн хөгжлийг хангах зорилготой улсын төсөв, ШУТИС-ийн санхүүжилттэй захиалгат төсөл, гэрээт ажлын орлого
 - 4.1.2 Төвөөс явуулсан сургалт судалгааны үйл ажиллагаанаас орох орлого
 - 4.1.3 Багшийн хөгжлийг дэмжих зорилгоор хамтарсан хөтөлбөр, төсөл хэрэгжүүлэх гадаадын хандивлагч түншлэгчдээс олгосон санхүүжилт
 - 4.1.4 Багшийн хөгжлийг дэмжигч дотоод, гадаадын тэтгэлэг, сангийн хөрөнгө оруулалт
 - 4.1.5 Бүрэлдэхүүн сургуулиуд, институт нь тухайн жилийн орлогын 2-5 хувийг багшийг хөгжүүлэх үйл ажиллагаанд зориулан төсөвт тусгаж зарцуулна.
 - 4.1.6 Хууль тогтоомжоор хориглоогүй санхүүгийн бусад эх үүсвэр
- 4.2 Төвийн санхүүгийн үйл ажиллагааг Их сургуулийн дансыг ашиглан явуулна.
- 4.3 Төвийн хөрөнгө санхүүгийн эх үүсвэрийг дүрэмд зааснаас өөрөөр зарцуулахыг хориглоно.